

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ  
12 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл**

2021 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдааныг 1, ээлжит хуралдааныг 2 удаа зохион байгуулсан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааныг 2021 оны 11 дүгээр сарын дүнгээр 13 удаа хуралдуулж нийт 48 асуудлыг хэлэлцэж 41 тогтоол гаргасан. Тухайлбал, Зохион байгуулалтын асуудлаар-8, Хурлын хороодын үйл ажиллагааг дэмжих асуудлаар-2, Тогтоолд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох асуудлаар-3, Орон нутгийн өмчийн асуудлаар-7, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хуваарилалтыг батлах тухай, Хүн амын эрүүл мэндийг дэмжих жил болгон зарлах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дэд зөвлөл байгуулж, дүрмийг батлах тухай, Аймгийн Мал аж ахуйн салбарын бодлого, чиглэлийг батлах тухай, Сум, багийн нэр, дугаарыг уламжлах тухай, Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах, тайлагнах журам, Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлийг олгох, хяналт тавих журмыг шинэчлэн батлах тухай, Газар тариалан, хадлан тэжээл бэлтгэх техник, тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээний тариф тогтоох тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлд санал өгөх тухай, 2022 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, зориулалт, байршилын саналыг уламжлах тухай, Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид тусламж үзүүлэх тухай, ГХУСАЗСЗ, дэд зөвлөлүүдийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай, Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр батлах тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж тогтоол гаргасан байна.

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл**

Аймгийн Удирдах ажилтны ээлжит шуурхай зөвлөгөөнийг 12 дугаар сарын 25-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газарт зохион байгуулж, хуваарийн дагуу Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газрын удирдлагууд тухайн сарын хэрэгжүүлсэн ажил, анхаарах асуудлыг танилцуулж, цаг үеийн асуудлын талаар хэлэлцэж, аймгийн Засаг дарга хэлтэс, агентлагийн дарга нарт үүрэг даалгавар өгсөн.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/143 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 агентлаг, 19 сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна.

Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолын дагуу байгууллагын даргын тушаалаар батлагдсан үнэлгээний баг аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдын 2021 оны жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, журмын дагуу албан хаагчдыг шагнаж урамшууллаа.

Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөл төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаал, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын сул орон тооны сонгон шалгаруулалтыг нийт дэс түшмэлийн 81, ахлах түшмэлийн 9, туслах түшмэлийн 25, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын 3, нийт 118 сул орон тоон дээр зарлаж, төрийн албаны тусгай шалгалтыг 2021 оны 12 дугаар сарын 15, 28, 30-ны өдрүүдэд холбогдох журмын дагуу амжилттай зохион байгууллаа.

**Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд  
Татвар төлөлт**

2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсөвт 1975.9 сая төгрөг төвлөрүүлэхээс 2500.8 сая төгрөг төвлөрүүлж,

төлөвлөгөөг 126.5 хувиар, орон нутгийн төсөвт 11444.3 сая төгрөг төвлөрүүлэхээс 13754.9 сая төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг 120.1 хувиар тус тус биелүүллээ.

### **Хөрөнгө оруулалт**

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 41.177.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 45 төсөл арга хэмжээ батлагдсанаас орон нутагт 22.293.7 сая төгрөгийн эрх шилжиж ирснээс 2021 оны 12 дугаар сарын 30-ны байдлаар 13.773.4 сая төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.666.2 сая төгрөгийн 28 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 1.810.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

### **Санхүүгийн хяналт**

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2019-2020 оны үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж, улсын ахлах байцаагчийн 2 төрлийн актаар 4.6 сая төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоогдсон. Өргөдөл хүсэлтээр Ихтамир сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн байдлд хяналт шалгалт хийж, улсын байцаагчийн актаар 5.0 сая төгрөгийг сумын ЗДТГ-ын төсвөөс санд нөхөн төвлөрүүлэхээр, Ирээдүй цогцолборын үйл ажиллагаанд хэсэгчилсэн хяналт шалгалт хийгдэж, хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаатай холбоотой 9.4 сая төгрөгийн нөхөн төлбөрийг аймгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэхээр тус тус шийдвэрлэлээ.

### **Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд**

#### **Хууль, хяналт**

2021 оны 12 дугаар сард 9 удаагийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол тохиолдосноос объектын гал түймэр 3, мал, амьтны гоц халдварт өвчин 5, эрэн хайх аврах ажиллагааны дуудлага 1 удаа тус тус тохиолдсон байна. УЦУОШТ-с цаг агаарын мэдээ 5 удаа тодотгосон, хойд бүсээс 15, хойд бүст 10, ОБЕГ-с 28 мэдээ хүлээн авч удирдлагад танилцуулсан, ОБЕГ-т 10 мэдээг дамжуулсан, ОБЕГ-н “Онцгой” станцаар 108, утсаар 120, мессенжрээр 210, “Зүүм” цахим программаар 25 удаа сүлжээнд орж мэдээ дамжуулж, хүлээн авч ажилласан. Тус аймгийн сумдын Засаг дарга, ЗДТГазрын дарга нарт цаг агаарын аюулт үзэгдэлийн мэдээг 2 удаа, covid-19 цар тахалаас урьдчилан сэргийлэх анхааруулах, сэрэмжлүүлэх мэдээ, мэдээллийг 125 удаа цаг алдалгүй дамжуулж бүртгэл хөтөлж ажилласан байна.

Дэлхий дахинд тархаад байгаа коронавируст халдвар “Covid-19”-ээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын хурлын тэмдэглэл, тушаал, ОБЕГ-аас өгсөн тушаал, үүрэг, даалгавар, аймгийн Онцгой комиссын албан даалгавар, хурлын тэмдэглэл, тушаал, аймгийн Засаг даргын захирамжуудын биелэлтийг гарган Онцгой комиссын даргад танилцуулан, Онцгой комиссын орлогч, Онцгой байдлын газрын даргаар хянуулан Улсын Онцгой комиссын Шуурхай штаб, ОБЕГазар болон Хойд бүсийн төвд тухай бүр цаг хугацаанд нь хүргүүлсэн байна.

Коронавируст халдвар /Covid-19/-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд зориулан аж ахуй нэгж, байгууллагаас мөнгөн хандив, эд материалын тусламж өгсөнийг болзошгүй эрсдэлийн үед шаардагдах амны хаалт, нэг удаагийн хувцас болон бусад шаардлагатай эд зүйлийн нөөцийг бүрдүүлэн бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Чулуут сумын Өлзийт гол багийн Дөрөө хангинахын, Хүрэм багийн Ламын өвөлжөөний голомтонд байгаа үхрийг тусгаарлан ээмэгжүүлэлт хийгдэж байна. ЗДТГ-н 15, Мал эмнэлгийн газрын 7, ОБГ-ын 4, Цагдаагийн газрын 2, нийт 28 албан хаагч, 7 автомашин, 2 мотоцикль нийт 9 тээврийн хэрэгсэлтэй үүрэг гүйцэтгэж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/177 дугаар захирамжийн дагуу хорио цээрийн дэглэм тогтоон ажиллаж байна. Эрдэнэмандал сумын Тээл багийн Хужиртын голомтод ОБГ, Мал эмнэлгийн газраас ажиллаж байна.

Өндөр-Улаан сумын Хануй багийн Согоот амны “Зост эрэг” гэх газар өвөлжиж байгаа малчин А –нийн хотноос мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний шинж тэмдэг бүхий шуурхай дуудлага сумын МЭТ-т 2021 оны 12 сарын 06 өдөр ирсний дагуу 2021 оны 12 сарын 07 өдөр дуудлага өгсөн айлын голомтруу малын их эмч Б.Мөнх-эрдэнэ

орж шаардагдах дээж материалыг заавар арга зүйн дагуу авч УМЭАЦТЛ –луу шинжлүүлэхээр явуулсан. Малын эмчийн анхны онош малын үзүүлж буй шинж тэмдгийн дагуу тус суманд сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/185 дугаар захирамжийн дагуу хязгаарлалтын дэглэм тогтоон ажиллаж байна. Бор өлөн, Согоот гэдэг газар пост гарган ажиллаж байна.

Жаргалант сумын Баянцагаан багийн нарийн булаг гэдэг газраас шүлхий өвчний шинж тэмдэгтэй малаас малын их эмч гантулга малд үзлэг хийн, дээж авч тархварзүйч алтан-од дээжийг лабораторит хүргүүлэн тухайн бүс нутагт хязгаарлалтын дэглэм тогтоох захирамж гарган пост гаргаж ажиллаж байна.

Чулуут, Эрдэнэбулган сумдад “Буянт мянгат” ХХК-аас Хятад улсад үйлдвэрлэсэн иргэд олон нийтэд гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, зарлан мэдээллийг цаг алдалгүй хүргэх, чанга яригчтай, дуут дохиог сумын Засаг даргын нөөц хөрөнгөөр 17.2 сая төгрөгийг шийдвэрлүүлж суурилуулан, ашиглаж байна.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, шар усны үерээс урьдчилан сэргийлэх, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, цаг үеийн мэдээ мэдээлэл төрлийн шторкыг “АВ”, “Тамир” телевизүүдээр өдөрт 10 удаагийн давтамжтайгаар нийт 220 минут нэвтрүүлж урьдчилан сэргийлэх чиглэлээр 31,246 иргэнд ухуулга сурталчилгаа хийж ажиллалаа.

“АВ” телевиз, “Тамир” телевиз цаг үеийн холбогдолтой тодруулга буланд 5 удаагийн ярилцлага өгч “Архангайн амьдрал сонинд 2 удаа мэдээ нийтлүүлсэн. Аймгийн ард иргэдийг бодит үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор Улсын Онцгой комисс, Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газрын вэб сайтаас мэдээг авч олон нийтийн хэрэгслээр түгээж байна.

2021 оны 11-р сард аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 384 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 120, хулгайлах гэмт хэрэг 121, иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 41, малын хулгайн гэмт хэрэг 60, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 25, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 103, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 30, гэмт хэргийн илрүүлэлт 60.8 хувьтай байна.

Нийт 18192 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 17374 иргэнд 674374.8 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 1293.0 сая төгрөг, нөхөн төлүүлэлт 54.1 хувьтай байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2021 оны 12 дугаар сард шинэ жилийн баяр тохиож байгаа тул бэлэг, хүнсний бүтээгдэхүүний хугацаа, хаяг шошго, хадгалалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг томоохон худалдааны төв, цэг салбар, дэлгүүрүүдэд хийлээ. Шалгалтаар нийт 20 дэлгүүр павилоноос гарал үүсэл нь тодорхойгүй, хадгалах хугацаа дууссан, хаяг шошгын зөрчилтэй 112 нэр төрлийн 3,811,683 мянган төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг буцаан татуулж тухайн байгууллагын дотоод хяналтаар устгалд оруулахаар шийдвэрлэлээ. Хяналт шалгалт үргэлжилж байна

## **Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд**

### **Боловсрол**

Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын үнэлгээний төв хамтран “Хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх арга зүй, аргачлал” сэдэвт сургалтыг 12 сарын 21-24-ний өдрүүдэд зохион байгууллаа. Уг сургалтад Архангай аймгийн ЕБС-ын 1000 гаран багш нар хамрагдлаа.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас боловсролын салбарын бүх ажилтан, албан хаагч нар, ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдад албан ёсны зөвшөөрөлтэй office-365 програмын эрхийг олголоо. Ингэснээр хэрэглэгч бүрд онлайнаар ажиллах, суралцах илүү боломжийг олгож байгаа бөгөөд хэрэглэгч бүрт gmail хаяг нээгдэж байгаа юм. Gmail хаяг тус бүр дээр тухайн хэрэглэгчийн өөрийн файлыг нууцлалтай хадгалах онлайн багтаамжийн хэмжээ 1 Терабайт байх юм.

## Соёл урлаг

Аймгийн Нийтийн номын сан коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед уншлагын танхимын 50 хувийн дүүргэлттэй халдвар, хамгааллын дэглэмийг мөрдөн танхимын үйлчилгээ хүргэн ажиллаж байна.

Нийтийн уншлагын танхимаар 12 уншигч шинээр бүртгэж, 335 ирэгсэдэд 42 ном, 146 сонин сэтгүүл, хүүхдийн уншлагын танхимаар 85 уншигч шинээр бүртгэж, 1022 ирэгсэдэд 1100 ном, гэрээр ном олголтоор 45 ирэгсэдэд 120 номоор тус тус үйлчилсэн байна.

Халхын анхдугаар Зая бандида, билгүүн номч, соён гэгээрүүлэгч, яруу найрагч Сунтарын Лувсанпринлэй хутагтын мэндэлсний 380 жилийн ойг угтан энэ жилийн “Хангайн цом 2021” яруу найргийн наадмыг 11 дүгээр сарын 29-ний өдөр Ардын жүжигчин Д.Ичинхорлоогийн нэрэмжит аймгийн Хөгжимт драмын театрт зохион байгууллаа. “Хангайн цом 2021” яруу найргийн наадамд 70 гаруй найрагч шүлгээ бүртгүүлж уралдсанаас 2 дугаар шатанд 20 яруу найрагч оролцож, МЗЭ-ийн болон Монголын Урчуудын эвлэлийн шагналт зохиолч Мягмарын Амархүү тэргүүлж, “Хангай цом-2021” яруу найргийн наадмын цомыг хүртлээ.

Тус наадмын ерөнхий зохион байгуулагчаар Архангай аймгийн утга зохиолын “Хантамир” төв, аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрдэнэбулган сумын Засаг даргын Тамгын газар оролцсон бол С.Жамьянгаравын нэрэмжит аймгийн Нийтийн номын сан, “Номын соёлт ертөнц” ТББ, аймгийн Соёлын хэлтэс, МЗЭ-ийн Яруу найргийн үндэсний төв хамтран ажилласан байна.

Аймгийн Соёлын хэлтэс, Зураач урчуудын холбоо, Нийтийн номын сан хамтран 12 дугаар сарын 6-8-ны өдрүүдэд “Бидний урлахуй-2021” уран бүтээлийн үзэсгэлэнг аймгийн Нийтийн номын сангийн үзэсгэлэнгийн байранд зохион байгууллаа. Үзэсгэлэнд 15 уран бүтээлчийн 60 гаруй бүтээлч дэлгэгдэж, 3 өдөр олон нийтэд сурталчилан таниулав.

Аймгийн Хөгжимт драмын театрын “Өвөл цагийн нээлт”-ийн шинэ уран бүтээл болох УСГЗ, Төрийн шагналт зохиолч Ц.Доржготовын романаас сэдэвлэсэн жүжгийн зохиолч Батхуяг, УДЭТ-ын найруулагч МУУГЗ Ч.Түвшингийн найруулга “Улаан орхимжны давалгаа” эмгэнэлт түүхэн жүжгийг 2021 оны 12 дугаар сарын 17,18,19, 20-ны өдрүүдэд амжилттай тоглолоо. Тус жүжгийн үзэгчдийн 50 хувийн дүүргэлтэйгээр 4 удаа тоглож, 350 гаруй үзэгчдийн хүртээл болгосон байна.

## Эрүүл мэнд

Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авч үнэлгээ дүгнэлт хийх, улмаар тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, үйл ажиллагаандаа дотоод зохион байгуулалтыг оновчтой болгох зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/578 дугаар тушаалын дагуу “Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг үнэлэх” 1 сарын аяныг Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/217 дугаар тушаал гарган зохион байгуулсан.

Аяны хугацаанд аймгийн Нэгдсэн эмнэлэг /2021.10.15-12.20 хүртэл/ 9 удаа сэтгэл ханамжийн судалгаа авч нийт амбулаторийн үйлчлүүлэгчид 160, хэвтэн эмчлүүлэгчдээс 70 хүнийг хамруулж, 7 хоногийн 4 дэх өдрийг “Үйлчлүүлэгч иргэдийг сонсох өдөр” болгон эмнэлгээр үйлчлүүлэгчдээс судалгааг авсан. Аяны хүрээнд ЭМГ-аас цахимаар нийт 408 амбулаторийн үйлчлүүлэгч, 71 хэвтэн эмчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг авч дүгнэн ЭМХТ-д хүргүүлсэн.

Швейцарын Хөгжлийн агентлагаас үзүүлж буй тусламжийн хүрээнд 112,8 сая төгрөгийн өртөг бүхий MOBIRAD-50 маркийн зөөврийн рентген аппаратыг “СИ АЙ ТИ” ХХК-ны инженер техникийн ажилтнууд 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүлээлгэн өгч оношлогооны чадамжийг нэмэгдүүлсэн. Тус рентген аппаратыг нийлүүлэгч байгууллагын зүгээс дагалдах хэрэгсэл, бичиг баримтуудыг бүрэн гүйцэд өгч ашиглалтын сургалтыг рентгений эмч, техникч нарт хийсэн.

Азийн хөгжлийн банкны “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 Ковид-19-ийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд хэрэгжсэн Нэгдсэн эмнэлгийн төвлөрсөн

ариутгалын тасгийн барилгын их засвар, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийж, 2021 оны 4-р улиралд ашиглалтад оруулснаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт төвлөрсөн ариутгалын тасагтай боллоо.

Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд нийт 24 эрүүл мэндийн байгууллагуудад 194,5 сая төгрөгийн өртөг бүхий 99 компьютерыг хүлээлгэн өгсөн.

Орон нутгийн иргэдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн болон эх, нярайн яаралтай тусламж үйлчилгээг цаг алдалгүй, хүртээмжтэй, чанартай хүргэхэд аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төвийн эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нарыг чадавхижуулах зорилгоор НҮБ-ын хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн яам, ЭХЭМҮТ, АШУҮИС-ийн багш, мэргэжилтнүүд 11 дүгээр сарын 29-30-ны өдрүүдэд сургалт зохион байгуулж 45 эмч, эх баригч бага эмч нар хамрагдсан.

Мөн сургалтын хүрээнд “Эх барихын цомог”-ийг Нэгдсэн эмнэлгийн НҮЭМК, 19 сум, 3 өрхийн эрүүл мэндийн төвд “Анхны тусламжийн багц” хүлээлгэн өгсөн.

PCR шинжилгээнд 4681 хүнийг хамруулж, түргэвчилсэн шинжилгээнд 3849 хүнийг хамруулж, 1519 батлагдсан тохиолдлыг илрүүлж, тусгаарлан эмчилгээнд хамруулсан. Батлагдсан тохиолдлуудын тандалт судалгааг хийж, 3240 хавьтлыг тогтоож, хянасан. Вакцинжуулалтын 23 цэгт коронавирүсийн эсрэг вакцинжуулалтын 1 дүгээр тунд 244, 2 дугаар тунд 778, 3 дугаар тунд 10869 хүнийг хамруулсан байна.

Улирлын томуугийн эсрэг вакцинжуулалтад 2-11 насны 7150 хүүхдийг хамруулсан.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын орчинд коронавирүсийн болон бусад халдвараас сэргийлэх, хүүхэд, багш, ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр цэцэрлэгүүдийн удирдах ажилтнуудыг чадавхижуулах сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулж, хөдөөгийн сумын 20 цэцэрлэг, аймгийн төвийн 15 цэцэрлэг нийт 35 цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нар оролцож мэдлэгээ дээшлүүлсэн.

Төрийн байгууллагын орчинд коронавирүсийн халдвараас сэргийлэх, ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр төрийн байгууллагуудын хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтнуудыг чадавхижуулах сургалтыг 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдөр зохион байгуулж, 30 байгууллага оролцож, мэдлэгээ дээшлүүлсэн.

Архангай аймагт батлагдсан коронавирүст халдварын тохиолдлуудын насны бүлэг, тохиолдол нас баралтын харьцаа, вакцинжуулалт, батлагдсан тохиолдлуудад илэрсэн шинж тэмдэгийг насны бүлэгтэй харьцуулах, шинжилгээнд эерэг илрэлтийн хувь, эрсдэлт хүчин зүйлийг насны бүлэгтэй харьцуулах зэрэг үзүүлэлтээр судалгааг хийж, боловсруулан, дүгнэлт, зөвлөмжийг гаргасан.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Боловсролын газар, сумын Эрүүл мэндийн төвүүдийн хамтарсан ажлын хэсгийг томилон, хариу арга хэмжээнд орон нутгийн салбар хоорондын хамтын ажиллагаа, үүрэг, оролцоонд хийх үнэлгээг 2021 оны 12 дугаар сарын 15-21-ны хооронд хийж, дүгнэлт зөвлөмж гаргасан.

Сүүлийн 2 жилд шинээр сүрьеэгээр өвдсөн сумын иргэдийн ойрын хавьтлуудыг аймгийн Нэгдсэн эмнэлэг дээр авчирч, рентген шинжилгээ, сүрьеэгийн эмчийн үзлэгт хамруулах үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 19 сумын Эрүүл мэндийн төвөөс 2-6 удаагийн давтамжтайгаар нийт 312 хавьтлыг үзлэг, оношилгоонд хамруулж, сүрьеэгийн 11 шинэ тохиолдлыг илрүүлж, 100 хувь эмчилгээнд хамруулсан.

### **Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал**

2021 оны 12 дугаар сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 1107 иргэн бүртгэлтэй байгаагаас 538 эмэгтэй. Шинэ ажлын байр 1131 үүнээс байнгын ажлын байр 574, улирлын ажлын байр 209, түр ажлын байр 348 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 99, зуучлал 961 байна. Тухайн сарын 16-ны байдлаар 167 иргэн шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 10, бага- 46, суурь-191, бүрэн дунд- 651, техникийн болон

мэргэжлийн анхан шатны – 17, тусгай мэргэжлийн дунд- 21, Дипломын бакалаврын-171 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 16 иргэнийг LMIS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлсэн.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс 2021 оны 12 дугаар сарын байдлаар нийт 16572 тэтгэвэр, тэтгэмж авагчдад 54.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн хуулийн хугацаанд шуурхай олгож ажилласан байна.

2021 оны 12-р сарын байдлаар төсөвт байгууллагууд 2652.5 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй гарч байна. Энэ нь өмнөх сараас 50% буурсан бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийн өр 72.2 сая байгаагаас 29 хувийг төсөвт байгууллага эзэлж байна.

### **Гэр бүл, хүүхэд, залуучууд**

Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн гишүүдийн гэр бүл, хүүхдийн хөгжил, хамгааллын асуудлаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, эцэг эхийн зөвлөлийн туршлагаас хуваалцах, зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор “Эцэг эхийн зөвлөлийн гишүүдийг чадавхижуулах нь” сургалтыг зохион байгуулж 61 байгууллагын эцэг эхийн зөвлөлийн ахлагч, гишүүд оролцлоо.

Сургалтаар “Эцэг эхийн зөвлөл ажиллах хууль эрх зүйн орчин, чиг үүрэг, хэрэгцээ”, “Гэр бүлийн хүчирхийллийн болзошгүй эрсдлээс сэргийлэх нь”, “Хүүхэд хамгааллын бодлого” сэдвүүдээр мэдээлэл хүргэсэн.

“Цахим орчин- соёлтой хэрэглээ” аяныг 19 сумын 20 сургуулийн 15000 хүүхэд 1000 насанд хүрэгчдийн оролцоотойгоор зохион байгууллаа. Аяны үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан 4 сургуулийг шалгаруулан шагнаж урамшуулав. Хүүхэд, багш, эцэг эхчүүдийн цахим орчны талаарх мэдлэг нэмэгдүүлэх, цахим гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулсан.

### **Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд**

#### **Мал аж ахуй**

Улсын хэмжээнд 2021 оны мал тооллогын урьдчилсан дүнгээр 67.3 сая толгой мал, Архангай аймаг 5,6 сая мал тоолуулж, адуу, үхэр, хонины тоогоор улсдаа тэргүүлж байна

Малын хяналтын тооллогын ажлаар аймгаас томилогдсон төлөөлөгчид 2021 оны 12 дугаар сарын 08-наас 15-ны хооронд бүх суманд ажилласан. Суманд ажилласан дүнгээс харахад аймгийн хэмжээнд цаг агаар тогтуун, ихэнх нутгаар бага хэмжээний цастай, малын унд ус, бэлчээрийн хүрэлцээ хангамж өмнөх жилүүдтэй харьцуулахад сайн байна. Малын хорогдол гараагүй бөгөөд малчид болон сумууд өвс тэжээлийн нөөцийг харьцангуй сайн бэлтгэсэн, аймгийн хэмжээнд өвөлжилт хэвийн байна.

Аймгийн хэмжээнд тусгай хэрэгцээний сумын болон сум дундын отрын бүс тогтоох бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байгаа бөгөөд 2010-2020 онуудад сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 265.4 мянган га бэлчээрийг отрын нөөц нутгаар тогтоосон байна.

2021 оны 10 дугаар сарын 07-ны өдөр аймгийн Онцгой комисс хуралдан Ихтамир суманд Мал эмнэлгийн газар, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Тагнуулын хэлтсийн нийт 10 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй шуурхай ажлын хэсэг газар дээр нь ажиллаж сумын Засаг даргын “Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай” 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/149 дүгээр захирамжийн дагуу арга хэмжээ авч ажиллаж байна.

Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 21/4155 бүртгэлийн дугаартай шинжилгээний дүн, мал эмнэлгийн тасгийн саналыг үндэслэн ажлын сумын Засаг даргын “Хорио цээрийн дэглэм тогтоох тухай” 2021 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/150 дугаар захирамж гарсан.

2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар Архангай аймгийн Булган, Ихтамир, Чулуут, Өндөр-Улаан, Эрдэнэмандал, Жаргалант, Цэнхэр, Цахир, Өлзийт зэрэг 9 суманд шүлхий өвчний тохиолдлууд гарсан.

	Сум	Голомтын өрхийн тоо	Голомтын тоо	Постын тоо	Өвчилсөн малын тоо			Нийт
					Үхэр	Хонь	Ямаа	
1	Ихтамир	19	3	3 /2 буусан/	529	549	11	1089
2	Булган	1	1	2 /буусан/	1			1
3	Эрдэнэмандал	12	1	2	84	73		157
4	Чулуут	19	3	2	1170			1170
5	Жаргалант	6	1	1	31			31
6	Өндөр-Улаан	12	2	2	135			135
7	Цэнхэр	7	2	2	37			37
8	Цахир	1	1	1	4			4
	Нийт	77	14	15	1991	622	11	2624

Ихтамир, Булган, Эрдэнэмандал, Чулуут, Өндөр-Улаан, Цэнхэр, Жаргалант, Цахир, Өлзийт зэрэг 9 сумын 16 багийн нутагт гарсан шүлхий өвчний хорио цээрийн дэглэм, вакцин тарилгын байдал, вакцины хадгалалт, голомт бүхий газрын малчин өрхийн 195205 мянган м/кв талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн байдал зэрэгт хяналт тавин ажиллаж байна. /Мал эмнэлнийн хяналтын улсын байцаагч газар дээр нь ажиллаж байна.

Өвчлөл бүртгэгдсэн 9 сумын холбогдох албан тушаалтнууд, мал эмнэлгийн улсын байцаагч нарт мэргэжлийн заавар, зөвлөмжийг өгч ажиллахын зэрэгцээ Улсын онцгой комиссын Шуурхай бүлэгтэй хамтран орон нутагт ажиллаж мэргэжил арга зүйн болон хууль эрх зүйн туслалцааг үзүүллээ.

### **Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд**

#### **Байгаль орчин**

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн PAGE төслөөс жуулчдыг монгол ахуйд амьдрах, оролцоог бий болгох улмаар малчин өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэх, гадаад зах зээлтэй шууд холбох зорилго бүхий “Гэр ба байгаль” концепцийг Говь-Алтай, Баянхонгор, Архангай аймагт хэрэгжүүлж байгаа бөгөөд Тариат, Өгийнуур, Цэнхэр, Ихтамир сумдын нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалд оролцогч 10 иргэнийг хамруулж, төслийг эхлүүлээд байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Архангай аймаг нэгдэж 20 сая модыг 2030 он хүртэл үе шаттайгаар тарихаар Засгийн газартай гэрээ байгуулсан.

2021 оны 12 дугаар сарын 09-ний өдөр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас “Байгаль орчны өдөр” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, “Ойн салбарын зөвлөгөөн”, “Хог хаягдлын менежмент” гэсэн хоёр бүрэлдэхүүн хурлыг зохион байгуулж, 20 сая мод тарих ажлын төлөвлөгөө, хөрс усны судалгаа, арчлалт хамгаалалтын зөвлөмж зэрэг бодлогын бичиг баримтуудыг баталлаа.

#### **Барилга, дэд бүтэц, газар**

2021 оны 12 дугаар сард улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн дараах 8 барилгыг ашиглалтад хүлээн авч улсын комисс ажиллалаа.

- ✓ “Тэнгэрийн долоон од” ХХК-ний авто засвар сэлбэгийн дэлгүүрийн барилга
- ✓ “Маргад оюу бплдинг” ХХК-ний авто граж, угаалгын төвийн барилга
- ✓ Эрдэнэбулган сумын иргэн Ш.Лхагвын Гост ресторан
- ✓ “Гурван тамир” ХХК-ийн “Эсрэг эрчим” ТББ барилга

- ✓ “Рим мон консалтинг” ХХ-ний гүйцэтгэсэн Хашаат сумын эрүүл мэндийн барилгын хэсэгчилсэн засварын ажил
- ✓ “Тамир таун” ХХК-ийн гүйцэтгэсэн УЦУОШТ-ийн гадна усан хангамж ариутгах татуургын шугамын ажил
- ✓ “Констант консалтинг” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Эрдэнэбулган сумын 6 дугаар цэцэрлэг засварын ажил
- ✓ “Үлэмж Энержи” ХХК-ийн гүйцэтгэсэн иргэн Д.Булганбаярын Ихтамир суманд байрлах ШТС

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 13 дугаар тогтоолоор 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлуулсан. 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа газрын цахим системээр ирүүлсэн 232 хүсэлт, албан бичгээр ирүүлсэн 491 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын саналыг хүлээн авч, аймаг, сумдын хот суурингийн хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө, нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан. Аймгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, газар хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээг сум бүрээр газрын хэмжээ, байршил, зориулалт, газар ашиглуулах хэлбэрээр 2776 байршилд 2043,69 га газрыг тус тус тусган төлөвлөж батлуулсан.

Барилгын материалын лаборатори нь 2021 оны 12 дугаар сарын байдлаар давхардсан тоогоор 84 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 172 дээжинд сорилт шинжилгээ хийн үр дүнг хүлээлгэн өгч, 100010029401 тоот дансанд 5560500 төгрөг төвлөрүүлээд байна.

### **Хүнс, үйлдвэрлэл үйлчилгээ**

Эрүүл мэндээ хамгаалж эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд “Ажлын байрыг дэмжих” зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгож байна. Үүнд:

- “Хаан” банк 117 иргэн, аж ахуйн нэгжид 7,4 тэрбум төгрөг,
- “Төрийн” банк 46 иргэн, аж ахуйн нэгжид 9.0 тэрбум төгрөг,
- “Хас” банк 21 иргэн, аж ахуйн нэгжид 1.2 тэрбум төгрөг,
- “Голомт” банк 20 иргэн, аж ахуйн нэгжид 1,4 тэрбум төгрөгийн зээлүүдийг тус тус олгосон.

Ажлын байрыг дэмжих зээлийг 353 иргэнд 11,7 тэрбум төгрөг, 64 аж ахуйн нэгжид 9,7 тэрбум төгрөг, нийт 417 иргэн, аж ахуйн нэгжид 21,4 тэрбум төгрөгийн зээл олгож 823 ажлын байрыг хадгалсан байна.

Хөдөө аж ахуйг дэмжих зээлийг олгож эхлээд байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 1161 малчинд 14,2 тэрбум төгрөг, газар тариалангийн чиглэлээр 3 иргэн, аж ахуйн нэгжид 160.0 сая төгрөгийн зээл тус тус олгоод байна.

2020 оны сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт жилийн эцсийн байдлаар 700.8 сая төгрөг орж ирсэн бол 2021 оны сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт энэ оны эхний хагас жилийн байдлаар 989,3 сая төгрөг орж ирсэн байна. 2020 онд сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийг Цэнхэр, Хангай, Өндөр-Улаан сумын 65 иргэн, аж ахуйн нэгжийн төсөлд 240.0 сая төгрөгийн зээл олгож 98 ажлын байр бий болсон байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----